



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/612

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлэх, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг зөрчил дутагдалгүй хэрэгжүүлэн ажилладаг төсөв, санхүүгийн салбарын тэмдэглэлт өдрийн үйл ажиллагааны зардалд болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт арга хэмжээний зардлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Шаардлагатай хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын “Санхүүгийн хяналт дотоод аудит, эрсдлийн удирдлага” хөтөлбөрийн зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр
сарын 12-ны өдрийн А/612 дүгээр
захирамжийн хавсралт

/төгрөгөөр/

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зардлын зүйл	Мөнгөн дүн
Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын хоол, цайны завсарлаг, гарын авлага материалын зардал	5.000,000
Санхүүгийн салбарын шилдэг байгууллага, ажилтнуудын шагналын зардал	4.800,000
Өргөмжлөл хэвлүүлэх зардал	800,000
Ахмад санхүүчдэд хүндэтгэл үзүүлэх	1.600,000
Нийт зардал	12,200,000